

Zhong guo gai kuang. Beijing. 1995 номноос авав.

Орчуулсан доктор Ч. Таамаа  
(МУИС-ийн ГХСС, Хятад хэлний тэнхмийн эрхлэгч)

### **Бумбын сургаалын үндсэн үзэл баримтлал.**

Хятадын Бумбын сургаалын үзэл санааг анх Лао З үүсгэж, дараа нь Жуан зи үргэлжлүүлэн хөгжүүлсэн юм.

Хан улсын У ди хааны үеэс Хятадад “Күнзийн сургаалыг л дээдлэх” үзлийг хэрэгжүүлж байснаас хойш бусад төрлийн урсгалууд аажмаар устаж үгүй болсон ба гагцхүү Лао З-ийн Бумбын сургаал л Күнзийн сургаалын сүүдэр мэт байсаар байсан.

Бумбын сургаал нь хэдийгээр Күнзийн сургаалаас салгаж болохгүй хятадын уламжлалт үзэл санааны 3 том урсгалын нэг болсон төдийгүй зарим хүмүүсийн амьдралын гүн ухаан болж Хятад улсад ихээхэн нөлөөг үзүүлсний дээр олон үеийн туршид ялангуяа томоохон сэхээтнүүдийн дунд маш их түгэн дэлгэрчээ.

#### **Лао З.**

Лао З-ийн амьдралын тухай тодорхой нарийн мэдээлэл үгүй билээ. “Түүхэн тэмдэглэл” сударт тэмдэглэснээр Лао З (3 дан гэдэг нь дотночлон дууддаг нэр багш гэсэн утгатай үг) Ли овогтой, түүний нэр нь Эр (том чихт гэсэн утгатай үг) тэрээр Чу улсын Ку сяний (odoogийн Хөнан мужийн Лу И сянь) хүн бөгөөд Күнзтэй нэгэн үед амьдарч байсан ажээ.

Зарим сурвалж бичигт Лао З-ийг Күнзээс хэдэн арав ах гэсэн байдаг. Лао З нь Жоу улсын ордны жижиг түшмэл байсан ба хожим Жоу улсын хаан төр ялзран доройтож байгаагаас болж ордныг орхин явсан түүхтэй.

Лао З нь Күнзийн адил Хятадын эртний агуу их сэтгэгч юм. Түүний үзэл санааг агуулсан түүврийг хожим “Дао-Дэ-Зинь” буюу “Жам ёсны судар” хэмээх нэртэйгээр нийтлүүлсэн байдаг.

Лао З-ийн бүмбүйн сургаалын гол агуулга нь юу вэ?

**1. “Дао” (зам) нь “түмэн бодисын эх үндэс” юм.**

Лао З-ийн Бүмбүйн сургаал нь түүний “Тянь дао гуань” хэмээх үзлээс үүссэн юм. Тэрээр “Дао” нь “түмэн бодисын эх үндэс” гэсэн үндсэн санааг дэвшүүлсэн.

Лао З үзэхдээ: “Дао ” нь дэлхийн бүх л зүйлсийн эх үндэс болон захирагч ба тэнгэр газар бүтээгдэхээс өмнө байсан гэжээ. “Дао” нь хэлбэр дүрс байхгүй нүдэнд харагдахгүй гарг баригдахгүй, дуу авиа амт үнэр байхгүй нэгэн төрлийн эх захгүй, тодорхойгүй, цаг хугацаа орон зайд баригдахгүй өнө мөнхийн өөрчлөгдөшгүй зүйл ажээ.

Дэлхийн бүхий л зүйлс нь “Дао”-аар бүтээгдэхийн зэрэгцээ Дао-г дагаж байдаг. Энэхүү “Дао” гэсэн ойлголт нь Лао З-ийн үзлийн гол үндэс суурь юм.

**2. Эсрэг тэсрэг зөрчилдөн, харилцан шилжих**

Лао З нь “Дао” гэсэн ойлголтоос үүдээд дэлхий дээрх аливаа зүйлс нь өөртөө эсрэг тэсрэгийг агуулж тэрхүү эсрэг тэсрэгүүд нь зөрчилдөн өөр хоорондоо хөгжиж өөрчлөгдөж байхыг харжээ. Жишээ нь: Байх байхгүй, хүнд хөнгөн, урт богино, өндөр нам, сайхан муухай, өмнө хойно, хатуу зөвлөн, хүчирхэг ба сул дорой, нэртэй нэргүй, жаргал зовлон, том жижиг, төрөх үхэх, цэцэн тэнэг, ялах ялагдах зэрэг нь харилцан эсрэгцэн оршиж мөн шилжиж өөрчлөгддөг ажээ.

Бүх л зүйлс нь оршин тогтнож, байр сууриа олохоор хичээж байдаг. Гэхдээ оршин тогтох гэж хичээж байхдаа сүйрэл мөхөл рүүгээ чиглэн явж байда жамтай.

Хүмүүс оюун ухаан, хүч чадал, тэмцлээр аз жаргалыг олох гэж хичээдэг ч хичнээн их хүн үүнээс болоод их зовлонг амссан байдаг гээд Лао З үүнээс “ зовлон жаргалыг түшсэн, жаргал зовлонг дагасан байдаг” гээд “гай зовлон аз жаргалыг дагуулдаг, жаргал нь зовлонг агуулсан байдаг ” гэжээ.

Энэхүү диалектик үзэл нь Лао З-ийн үзэл санааны охь дээж төдийгүй хойч үеийнхэнг гэгээрүүлсэн ихээхэн ач холбогдол бүхий болжээ.

### 3. Хүчээр биш эвээр, ертөнцийн жам ёсоор явагдах

Лао З, Күнз мэт сэтгэгчидийн үзэл санаа нэгэн адилгүй байсан ба Лао З нь “Тянь дао гуань”-д онцгойлон судалгаа хийсний дотор байгалийг онцгойлон үзсэн байдаг.

Тэрээр “Тянь дао” нь байгаль юм гэсэн дүгнэлтийг гаргасан. Энэ нь байгаль эх нь цаанаасаа л байдаг юуны ч төлөө биш, хэнд ч захирагдахгүй, түмэн бодис урган өсөж байгаа нь бүгд л байгалийн хэрэг гэсэн утгатай ажээ. Жишээ нь: Шүүдэр буух нь хэний ч зоргоор биш байгалийн ердийн зүйл ба түүнтэй адил түмэн бодис өсөж өөрчлөгдж байгаа нь хэний ч хүслээр биш харин байгаль өөрөөсөө явуулж байгаа хэрэг жам ёсны зүйл хэмээн тайлбарладаг.

Түүнчлэн тэнгэр, газрын хамаг зүйл, хүний үйл хэрэг бүгд л үүнтэй адил өөрийн жам ёстой байдаг ажээ. Богд хүмүүн улсыг удирдахад хэдэн томоохон зарчмыг баримталж, хэрэг болгонд оролцох хэрэггүй ба ингэх аваас түмэн олон цаанаасаа хүндэтгэн бишрэх буй заа гэжээ.

Байгалийн жам ёсоор түмэн зүйлд хандвал бүх зүйл байгалийг дагах болдог. Нилээд зүйл болно гэж бодсон ч бутэхгүйд хүрвэл байгалийн эсрэг юу ч хийсний хэрэггүй ба аяндаа сайхан болно гэсэн байдаг.

Үүнээс үзвэл Лао З нь Күнзийн “ёслолоор удирдах” болон хууль баримтлагч нарын “хуулиар удирдах” онолын аль алиныг эсэргүүцдэг билээ.

### 4. Дэлхий ертөнцтэй зөрөлдөхгүй, тайван амгаланг хүсэх

Энэ нь Лао З-ийн амьдралын ухаан гүн ухаан юм. Энэхүү үзэлд Лао З-ийн “Хүн аливаа зүйлд хүлээцтэй байх, байгаа байдалдаа сэтгэл хангалуун байх, идэвхи чармайлт гарган сайн сайхны төлөө тэмцэхгүй байх гэсэн онол” гол баримтлал нь болдог.

Тэрээр аливаа зүйл нь дорой буурай байх үедээ амьдрах эрмэлзлэл их байдаг, гэхдээ хүчирхэг болсон цагт хүчтэй болбол үхэлтэй ойртох болдог ба харгис хүмүүс нь ихэвчлэн сайхан үхлээр үхэж чадахгүй гэж үзжээ.

Дэлхий дээрх хамгийн уян зөөлөн зүйл бол ус, гэвч ус нь хатуу зүйлийг ч нэвтлэн гардаг ба түүнийг ямар ч хүн дийлж чадахгүй. Тиймээ "Дорой буурай нь хүчирхэгээ ялна, зөөлөн нь хатууг дийлнэ" гэдэг. Ус ши төрлийн зүйл нь Дао-тай хамгийн ойрхон гэсэн байдаг.

Хүний амьдрах ухаан ч ийм байх ёстай. Хүн дотор сэтгэлдээ уужмыг баримталж, хувия хичээхээс хол байх хэрэгтэй. Хөрөнгө чинээ, омголс зан хөөрхий биед зовлон авчирдаг. Өөрийн үйлийг зүйрлэшгүйд тооцогчийн үйл хэрэг нь өчүүхэн байдаг. Өөрийн биеийг өргөмжлөн сайрхагч өндөр дээд суудалд суудаггүй. Өрөөлийг ойлгодог хүн эрдэмтэй хүн байж таарни. Өөрийгөө ухаардаг хүн ухаантай хүн байж таарна. Хүчирхэг бүхэн доройтдиг гэдгийг ухаарч чи ойлгохгүй бол цагаасаа өмнө цал буурал болж өвгөрөх билээ.

Үргэлжлэл бий...